



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/409

Булган сум

“Wanderlust Mongolia” нүүдлийн театрын  
арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хүүхэд, залуучуудад соёл, урлагийн боловсрол олгох, олон улсын театрын уран бүтээлийг сурталчлан таниулах зорилгоор 2026 оны 04 дүгээр сарын 23-24-ний өдрүүдэд Булган суманд нүүдлийн театрын үзвэр үйлчилгээг иргэдэд хүргэх баг, бүрэлдэхүүний байрлах байрны зардалд 1,800,000 (нэг сая найман зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

